

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код 61.020; 13.340.40; 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Гар хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд тавих ерөнхий шаардлага	MNS 5622:20XX
Occupational safety and health. Personal protective equipment. General requirement for selection and use of hand protection. Protective gloves.	MNS 5622:2004-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь үйл ажиллагааны нь явцад ажилтны гарт механик үйлчлэл, химийн бодис, хүйтэн ба халууны үйлчлэл, цахилгаан хүчдэл, доргионоос нөлөөлөх эрсдэл бүхий ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна. Стандартад гарын сарвууны хэмжээ ба хөдөлгөөнд бэлэн бүтээгдэхүүний эвтэй байдлыг тодорхойлох туршилтын аргуудыг багтаасан болно.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

MNS 4931, Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал

MNS (ISO) 13688, Хамгаалалтын хувцсанд тавих ерөнхий шаардлага

ГОСТ 12.4.246, Гар хамгаалах хувийн хэрэгсэл. Бээлий. Техникийн ерөнхий шаардлага

3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1

гарын сарвуу

Дунд хурууны үзүүрээс бугуй хүртэлх биеийн хэсэг

3.2

сарвууны урт

Бугуй ба дунд хурууны үзүүр хоорондох зай.

3.3

бээлий

Гадны биетийн механик үйлчлэл, химийн бодис, цахилгаан хүчдэл болон бусад тааламжгүй нөлөөллөөс гарыг хамгаалах (гарыг тохой хүртэл, мөр хүртэл хаасан янз бүрийн урттай байж болно.) зориулалтаар хуруутай, хуруугүй загвараар хийгдсэн хэрэгсэл.

3.4

бээлийний алган тал

Сарвууны алган талыг бүрхсэн хэсэг.

3.5

бээлийний ар тал

Сарвууны ар талыг бүрхсэн хэсэг.

3.6

хөдөлгөөний чөлөөт байдал

ажил хийх үед гарын сарвууг чөлөөтэй хөдөлгөх чадвар.

ТАЙЛБАР: хөдөлгөөний чөлөөт байдал нь бүтээгдэхүүний материалын зузаан, түүний суналт, уян хатан байдал, бүтэц ба бээлийний хэмжээг зөв сонгохоос хамаарна.

3.7

гадны үйлчлэл

Хүний эрүүл мэндэд хор учруулж болох гадаад орчны хүчин зүйл.

3.8

тусгай хэрэглээний бээлий

Тодорхой мэргэжлийн хүмүүст зориулсан бээлий (цагдаа, мотоспортын гэх мэт).

3.9

механик үйлчлэлээс гар хамгаалах хэрэгсэл

Хурц ирмэгтэй материал, төмөр болон модон эдлэлээр бусад эд зүйлстэй харьцаж ажиллах үед гарын арьс салстыг эсгэж зүсэгдэх, гарын эд эсийг няцралт, зулгаралтаас хамгаалах, мэдрэмтгий эмзэг арьсанд харшил өгч үрэвсэхээс сэргийлэх зориулалттай, энэ стандартаар тогтоосон хэмжээгээр баталгаажуулсан хамгаалах хэрэгсэл.

3.10

дулааны үйлчлэлээс гар хамгаалах хэрэгсэл

Энд дулааны нөлөөнөөс гарын арьс, салстыг хамгаалах, мэдрэмтгий эмзэг арьсанд харшил өгч үрэвсэхээс сэргийлэх зориулалттай, энэхүү стандартаар тогтоосон нормоор баталгаажуулсан хамгаалах хэрэгсэл.

3.11

цахилгаан хүчдэлээс гар хамгаалах хэрэгсэл

Цахилгаан хүчдэлээс гарын арьс салстыг хамгаалах, мэдрэмтгий эмзэг арьсанд харшил өгч үрэвсэхээс сэргийлэх зориулалттай, энэхүү стандартаар тогтоосон хэмжээгээр баталгаажуулсан хамгаалах хэрэгсэл.

3.12

доргионоос гар хамгаалах хэрэгсэл

Доргионоос гар болон тулгуур эрхтэн хамгаалах, мэдрэмтгий эмзэг арьсанд харшил өгч үрэвсэхээс сэргийлэх зориулалттай, энэхүү стандартаар тогтоосон нормоор баталгаажуулсан хамгаалах хэрэгсэл.

4 Гар хамгаалах хэрэгслийн ангилал

4.1 Хийцээр нь дараах байдлаар ангилна.

- 4.1.1** Оёмол бээлий;
- 4.1.2** Полимер материалан бээлий;
- 4.1.3** Сүлжмэл бээлий гэж ангилна.

4.2 Хамгаалах зориулалтаар нь дараах байдлаар ангилна.

- 4.2.1** Механик үйлчлэлээс хамгаалах
- 4.2.2** Химийн бодисоос хамгаалах
- 4.2.3** Хүйтний үйлчлэлээс хамгаалах
- 4.2.4** Халууны үйлчлэлээс хамгаалах
- 4.2.5** Дулааны үйлчлэлээс хамгаалах
- 4.2.6** Цахилгаан хүчдэлээс хамгаалах
- 4.2.7** Доргионоос хамгаалах

4.3 Гар хамгаалах хэрэгслийн бүтэц

4.3.1 Механик үйлчлэлээс гар хамгаалах хэрэгслийн бүтэц

- 1 100 хувийн хөвөн даавуун,
- 2 Арьсан,
- 3 Брезинтэн,
- 4 Ган торон

4.3.2 Химийн бодисоос гар хамгаалах хэрэгслийн бүтэц

4.3.2.1 Найрлагадаа нитрил агуулсан гар хамгаалах хэрэгслийн бүтэц

- 1 Материалын найрлагадаа нитрил агуулсан,
- 2 Урт нь 305 мм-ээс дээш,
- 3 Зузаан нь 0,8 мм-ээс дээш.

4.3.2.2 Найрлагадаа натурлатекс агуулсан гар хамгаалах хэрэгслийн бүтэц

- 1 Материалын найрлагадаа натурлатекс агуулсан,
- 2 Урт нь 305 мм-ээс дээш,
- 3 Зузаан нь 0.8 мм-ээс дээш.

4.3.2.3 Найрлагадаа неопрон агуулсан гар хамгаалах хэрэгслийн бүтэц

- 1 Материалын найрлагадаа неопрон агуулсан
- 2 Урт нь 305 мм-ээс дээш
- 3 Зузаан нь 0,8 мм-ээс дээш

4.3.2.4 Найрлагадаа винил /PVC/ агуулсан гар хамгаалах хэрэгслийн бүтэц

- 1 Материалын найрлагадаа неопрон агуулсан
- 2 Урт нь 258 мм-ээс дээш,
- 3 Зузаан нь 0,8 мм-ээс дээш.

4.3.3 Дулааны үйлчлэлээс гар хамгаалах хэрэгслийн бүтэц

EN 407-Kat III-д стандартчилагдсан KEVLAR ES, PVC-NOPPEN агуулсан хөвөн даавуу, брезент болон азбестэн эдлэлүүд

4.3.4 Цахилгаан үйлчлэлээс гар хамгаалах хэрэгслийн бүтэц

EN 60903-Kat III-д стандартчилагдсан натурлатекс, PVC-NOPPEN агуулсан эдлэлүүд

4.3.5 Доргионоос гар хамгаалах хэрэгслийн бүтэц

EN 10819-Kat III-д стандартчилагдсан натурлатекс, PVC-NOPPEN агуулсан эдлэлүүд

5 Ерөнхий зүйл

5.1 Зорилго

Энэхүү стандарт нь ажлын байранд ажилтны гарыг механик үйлчлэл, химийн бодис, хүйтэн ба халууны үйлчлэл, цахилгаан хүчдэл, доргионоос хамгаалах оёмол, полимер материалан, сүлжмэл бээлийд тавих шаардлагыг тогтооход оршино.

5.2 Ерөнхий шаардлага

- 5.2.1** Бээлийний хийц загвар, технологи нь бээлийг зориулалтаар нь ашиглах үед хамгаалалтын ба эдэлгээний зайлшгүй шаардлагыг хангасан байна.
- 5.2.2** Бээлий, түүнийг хийсэн материал нь ажиллагсдын гарын арьсанд хор хөнөөлтэй үйлчлэл үзүүлэхгүй байна. Хэрвээ бээлийг зохион бүтээхэд оёдол хэрэглэсэн бол материал ба оёдлын бат бөх чанар нь бээлийний шинж чанарт эсрэгээр нөлөөлөхгүй байна.
- 5.2.3** Дохионы бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үед гэрэл ойлгох материалыг бээлийний ар талын гадаргуугийн 50 %-аас их байхаар ашиглана.
- 5.2.4** Тухайн бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэлийн болон техникийн үзүүлэлтийн баримт бичигтээ эрх бүхий мэргэжлийн байгууллагын лабораториор шинжлүүлж, чанарын баталгаажуулалт хийлгүүлэн тохирлын гэрчилгээ авсан эсэхээ тодорхой тусгасан байна.
- 5.2.5** Бээлий нь хөнгөн, гар, хурууны хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хийгдсэн, олон дахин угааж цэвэрлэх боломжтой, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлагад нийцсэн байна.
- 5.2.6** Бээлийний эдэлгээ даах чадвар, зүсэлт тэсвэрлэх чадвар, давтан хэрэглэх боломж, хатгалт тэсвэрлэх чадвар, химийн бодисоос хамгаалах чадварыг В

хавсралтаар тогтоосон байна .

5.3 Тусгай шаардлага

5.3.1 Оёмол бээлийнд тавигдах шаардлага

Оёмол бээлий нь хүснэгт 1-т үзүүлсэн шаардлагад тохирсон байна.

Хүснэгт 1

Оёмол бээлийний чанарын үзүүлэлт

Бүлэг ба дэд бүлэг	Чанарын үзүүлэлт	Нэгж	Норм
Оёмол бээлий	Шаардлагатай зохион бүтээлтийн элементүүдийн хэмжээснүүд үндсэн шугаман хэмжээнүүд, см, багагүй	см	Техникийн бичиг баримт, тогтоосон журмын дагуу
	Ерөнхий урт	см	22
	Эрхий хурууны суурийн түвшин дээрх өргөн	см	12.5
	Эрхий хурууны урт	см	7.0
	Оёдлын тасралтын ачаалал	Н	250
Чичиргээнээс	Материалын давхаргын зузаан, см-ээс ихгүй	см	0.8
Халууны үйлчлэлээс (100°C хүртэл халсан гадаргуутай хүрэлцэх)	Материалын давхаргын зузаан, см-ээс ихгүй	см	0.9
Хүйтний үйлчлэлээс	Материалын давхаргын зузаан, ихгүй	см	0.9

5.3.2 Полимер материалан бээлийд тавих шаардлага

5.3.2.1 Нэхмэл суурин дээр хийсэн полимер материалан бээлийд тавих шаардлага
Даавуун, сүлжмэл буюу нэхээсгүй суурин дээр хийсэн полимер материалан бээлий нь хүснэгт 2-т үзүүлсэн шаардлагад тохирсон байна.

Хүснэгт 2

Даавуун, сүлжмэл буюу нэхээсгүй суурин дээр хийсэн полимер материалан бээлийний чанарын үзүүлэлт

Бүлэг ба дэд бүлэг	Чанарын үзүүлэлт	Хэмжээ
Полимер материалан бээлий	Шаардлагатай зохион бүтээлтийн элементүүдийн хэмжээснүүд Үндсэн шугаман хэмжээнүүд, см, багагүй:	Техникийн бичиг баримт, тогтоосон журмын дагуу
	Ерөнхий урт	24.0
	Эрхий хурууны суурийн түвшин дээрх өргөн	9.0
	Эрхий хурууны урт	7.0

Хүснэгт 2 үргэлжлэл

Хүчил ба шүлтийн улмаас	Хүчил ба шүлт нэвтрүүлэлт, ед.рН, ихгүй	1,0
Ус ба хоргүй бодисын уусмалаас	Ус нэвтрүүлэлт	Бээлий ус үл нэвтрүүлэх ёстой

5.3.2.2 Полимер материалаар хийсэн бээлий нь (гагнаасан, түрхлэгтэй) хүснэгт 3-т үзүүлсэн шаардлагатай тохирсон байна.

Хүснэгт 3

Полимер материалан бээлийний чанарын үзүүлэлтүүд

Бүлэг ба дэд бүлэг	Чанарын үзүүлэлт	хэмжээ
Полимер материалан бээлий	Гадаад байдал, гаднаас харагдах согог Үндсэн шугаман хэмжээснүүд, мм	Техникийн бичиг баримт, тогтоосон журмын дагуу
	Бээлийний өргөн	/110-130/ ±5
	Хананы зузаан	0,6-0,9
Ус ба хоргүй бодисын уусмалаас	Ус нэвтрүүлэлт	Бээлий ус үл нэвтрүүлэх ёстой
Хүчил ба шүлтийн уусмалаас	Хүчил ба шүлтийн нэвтрүүлэлт, ед.рН, ихгүй	1,0
	Ус нэвтрүүлэлт	Бээлий ус үл нэвтрүүлэх ёстой.
Цахилгаан гүйдлээс	Цахилгаанжилтын шинж чанар (өгөгдсөн хүчдэлд цахилгаан гүйх), мА, ихгүй	9,0
	Тасралтын үеийн оёдлын бат бөх чанар*	25,0
Биологийн хүчин зүйлүүдээс (бичил биет)	Ус үл нэвтрүүлэлт	Бээлий ус үл нэвтрүүлэх ёстой
* Түрхлэгтэй бээлийнд		

5.3.3 Сүлжмэл бээлийд тавигдах шаардлага

Сүлжмэл бээлий нь хүснэгт 4-д үзүүлсэн шаардлагатай тохирсон байна.

Сүлжмэл бээлийний чанарын үзүүлэлтүүд

Хүснэгт 4

Бүлэг ба дэд бүлэг	Чанарын үзүүлэлт	Норм
Сүлжмэл бээлий	Гадаад байдал	Техникийн бичиг баримт, тогтоосон журмын дагуу. Дараах бэлэн бүтээгдэхүүнд үйлчлэхгүй:
		Нийт талбайн нөхөөс 1,5 см-ээс их,
		Оёдлын ирмэгийн хэрээс алгассан,
		Сонгосон хос бээлийний зөрүү нь ерөнхий уртын дагуу 1см-ээс, өргөний дагуу 0,7см-ээс их,
	Үндсэн шугаман хэмжээснүүд, см, багагүй	
	Урт	21,0
	Өргөн	7,5
	Эрхий хурууны урт	7,5
	Манжетны суналт, мм, багагүй	140
	Манжетны буцалтгүй деформаци, %, ихгүй	6,0
	Үрэлт тэсвэрлэлт, эргэлтийн тоо, багагүй	100
	Цэгийн тасралтын эсэргүүцэл, давтамжийн тоо, багагүй*	150
	Зүсэлтийн эсэргүүцэл, Н/мм, багагүй	2,0
	Гал тэсвэрлэлт, с	Дээж шатах ба галыг унтраасны дараа уугих ёсгүй.
	Шаталтын эсэргүүцэл, с, багагүй	50
* Полимеран цэгэн түрхлэгтэй сүлжмэл бээлийд		

5.4 Эргономикийн шаардлага

5.4.1 Гарын сарвууны хэмжээ

Бээлийний хэмжээг сарвууны хэмжээгээр тодорхойлно. Гарын сарвууны хэмжээг сарвууны урт ба бүслүүрийн уртын хэмжилтээр тодорхойлно.

5.4.2 Хүснэгт 5-д гарын сарвууны антропометрийн хэмжилттэй харгалзах бээлийний үндсэн 6 хэмжээг үзүүлэв.

Сарвууны ба бээлийний өмсгөл хэмжээ

Гарын сарвууны хэмжээ			Бээлийний өмсгөл хэмжээ		
Сарвууны хэмжээ*	Сарвууны бүслүүр,мм	Сарвууны урт, мм	Үсгэн тэмдэглэгээ	Дундаж хэмжээ	Бээлийний хамгийн бага урт, мм
6	152	160	XS	6-7	220
7	178	171	S	7-8	230
8	203	182	M	8-9	240
9	229	192	L	9-10	250
10	254	204	XL	10-11	260
11	279	215	XXL	11-12	270
*утга нь сарвууны бүслүүрийг дүймд шилжүүлсэн сарвууны хэмжээний үзүүлэлт юм. /1 инч=25,4 мм/					

5.4.3 Тусгай хэрэглээний бээлий

Тусгай хэрэглээний бээлийний урт нь хүснэгт 5-д заасан хэмжээтэй тохирохгүй байж болно. Үйлдвэрлэгч тухайн бээлийг “Тусгай хэрэглээний бээлий” гээд хэрэглээний заавар дээр хүснэгт 5-д заасан утгатай тохирохгүй байгаа шалтгааныг тодорхой зааж өгнө.

5.4.4 Чимхлүүр ажил хийхэд эвтэй байх

Бээлий нь гарын хуруунуудыг чөлөөтэй хөдөлгөж, чимэхлүүр ажил хийхэд төвөггүй байх ёстой.

Хуруунуудын төвөггүй хөдөлгөөнийг гарын хөдөлгөөний чөлөөтэй байдлын түвшингээр тодорхойлно. Хөдөлгөөний чөлөөт байдлын түвшнийг 6-р хүснэгтээр үнэлнэ.

Гарын хөдөлгөөний чөлөөтэй байдлын түвшин

Хөдөлгөөний чөлөөтэй байдлын түвшин	Туршилтын шаардлагад тохирсон савааны хамгийн бага голч, мм
1	11
2	9.5
3	8
4	6.5
5	5

6 Гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

6.1 Механик үйлчлэлээс гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

Механик үйлчлэлээс гар хамгаалах хэрэгсэл, түүний баглаа боодол дээр зориулалт болон эдэлгээ даах чадвар (0-4 оноо), зүсэлт тэсвэрлэх чадвар (0-4 оноо), давтан хэрэглэх боломж (0-4 оноо), хатгалт даах чадвар (0-4 оноо-ыг тоон үзүүлэлтээр тэмдэглэсэн байна.

6.2 Химийн бодисоос гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

Хүснэгт 7

Найрлагадаа нитрил агуулсан гар хамгаалах хэрэгслийн
техникийн үзүүлэлт, ялгах өнгө- ногоон

№	Химийн бодисын нэр	Хамгаалах чадвар	Химийн бодисоос хамгаалах чадвар /цагаар/
1	Аммоны исэл	+++	480
2	Аммонийн ислийн хлорид	+++	480
3	Аммонийн ислийн нитрат	+++	480
4	Бензин	+++	500
5	Мөнгөний хэт исэл	+++	300
6	Борын хүчил	++	300
7	Бромид	+++	500
8	Түлш болон тоормосны бүх төрлийн шингэн	+++	500
9	Кальцийн хлорид, кальцийн дутуу исэл, кальцийн хэт исэл, кальцийн нитрат, кальцийн фосфат	++	300
10	Хлор	++	300
11	Цууны хүчил, цууны хүчлийн дутуу исэл, цууны хүчлийн хэт исэл	++	250
12	Этинолын төрлийн бүх бодисууд	++	200
13	Давсны хүчил	+++	200
14	Хүхрийн хүчил, Формалины хүчил	+	100
15	Мөнгөн усны исэл	++	200
16	Натрийн карбонат, давсны хүчил, натрийн хэт исэл, натрийн дутуу исэл	++	200
17	Дээр дурдаагүй болон органик бодисууд	+	100

ТАЙЛБАР 1: +++ Химийн бодисоос маш сайн хамгаалах бөгөөд химийн бодист тасралтгүй байх хугацаа урт,

ТАЙЛБАР 2: ++ Химийн бодисоос сайн хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 200 цагаас бага,

ТАЙЛБАР 3: + Химийн бодисоос хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 100 цагаас бага.

Найрлагадаа натурлатекс агуулсан гар хамгаалах
хэрэгслийн техникийн үзүүлэлт, ялгах өнгө- Хөх

№	Химийн бодисын нэр	Хамгаалах чадвар	Химийн бодисоос хамгаалах чадвар /цагаар/
1	Аммоны исэл	+++	400
2	Аммонийн ислийн хлорид	+++	400
3	Аммонийн ислийн нитрат	+++	400
4	Бензин	+++	500
5	Мөнгөний хэт исэл	++	200
6	Борын хүчил	++	200
7	Бромид	++	300
8	Кальцийн хлорид, кальцийн дутуу исэл, кальцийн хэт исэл, кальцийн нитрат, кальцийн фосфат	++	300
9	Этинолийн төрлийн бүх бодисууд	+	100
10	Давсны хүчил	++	200
11	Натрийн карбонат, давсны хүчил, натрийн хэт исэл, натрийн дутуу исэл	+	100

ТАЙЛБАР 1: +++ Химийн бодисоос маш сайн хамгаалах бөгөөд химийн бодист тасралтгүй байх хугацаа урт

ТАЙЛБАР 2: ++ Химийн бодисоос сайн хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 200 цагаас бага

ТАЙЛБАР 3: + Химийн бодисоос хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 100 цагаас бага

Найрлагадаа неопрон агуулсан гар хамгаалах хэрэгслийн
техникийн үзүүлэлт, ялгах өнгө- Улаан

№	Химийн бодисын нэр	Хамгаалах чадвар	Химийн бодисоос хамгаалах чадвар /цагаар/
1	Аммоны исэл	+++	480
2	Аммонийн ислийн хлорид	+++	480
3	Аммонийн ислийн нитрат	++	480
4	Бензин	+++	600
5	Мөнгөний хэт исэл	++	300
6	Борын хүчил	++	250
7	Бромид	++	400
8	Түлш болон тоормосны бүх төрлийн шингэн	+++	500
9	Кальцийн хлорид, кальцийн дутуу исэл, кальцийн хэт исэл, кальцийн нитрат, кальцийн фосфат	++	300
10	Хлор	++	300
11	Цууны хүчил, цууны хүчлийн дутуу исэл, цууны хүчлийн хэт исэл	+++	250
12	Этинолийн төрлийн бүх бодисууд	++	200
13	Давсны хүчил	++	200
14	Хүхрийн хүчил, Формалины хүчил, цайрын исэл	+	100
15	Мөнгөн усны исэл	++	200
16	Натрийн карбонат, давсны хүчил, натрийн хэт исэл, натрийн дутуу исэл	++	200
17	Дээр дурдагдаагүй болон органик бодисууд	+	100

ТАЙЛБАР 1: +++ Химийн бодисоос маш сайн хамгаалах бөгөөд химийн бодист тасралтгүй байх хугацаа урт,

ТАЙЛБАР 2: ++ Химийн бодисоос сайн хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 200 цагаас бага,

ТАЙЛБАР 3: + Химийн бодисоос хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 100 цагаас бага,

**Найрлагадаа винил /PVC/ агуулсан гар хамгаалах хэрэгслийн
техникийн үзүүлэлт, ялгах өнгө – Шар**

№	Химийн бодисын нэр	Хамгаалах чадвар	Химийн бодисоос хамгаалах чадвар /цагаар/
1	Аммоны исэл	++	480
2	Аммонийн ислийн хлорид	++	480
3	Аммонийн ислийн нитрат	++	480
4	Бензин	++	500
5	Мөнгөний хэт исэл	++	300
6	Борын хүчил	++	300
7	Бромид	++	500
8	Түлш болон тоормосны бүх төрлийн шингэн	++	500
9	Кальцийн хлорид, кальцийн дутуу исэл, кальцийн хэт исэл, кальцийн нитрат, кальцийн фосфат	++	300
10	Хлор	++	300
11	Цууны хүчил, цууны хүчлийн дутуу исэл, цууны хүчлийн хэт исэл	++	250
12	Этинолийн төрлийн бүх бодисууд	++	200
13	Давсны хүчил	++	200
14	Хүхрийн хүчил, Формалины хүчил, цайрын исэл	++	100
15	Мөнгөн усны исэл	++	200
16	Натрийн карбонат, давсны хүчил, натрийн хэт исэл, натрийн дутуу исэл	++	200
17	Дээр дурдагдаагүй болон органик бодисууд	++	100

ТАЙЛБАР 1: +++ Химийн бодисоос маш сайн хамгаалах бөгөөд химийн бодист тасралтгүй байх хугацаа урт,

ТАЙЛБАР 2: ++ Химийн бодисоос сайн хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 200 цагаас бага,

ТАЙЛБАР 3: + Химийн бодисоос хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 100 цагаас бага.

6.3 Дулааны үйлчлэлээс гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

- a. 1100 °C хүртэл дулаанаас хамгаалах чадвартай,
- b. Материалын нягт 825 г/мм.кв,
- c. Зузаан 15 мм-ээс дээш,
- d. Урт нь 320 мм-ээс 430 мм.

6.4 Цахилгаан үйлчлэлээс гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

- a. 5000 хүртэлх вольтын хүчдэлээс хамгаалах,
- b. Зузаан 0,5 мм-ээс 1 мм,
- c. Урт 360 мм-ээс 410 мм,
- d. -40°C +50°C-ийн нөлөөллөөс хамгаалах.

6.5 Доргионоос гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

- a. Доргионы хүчийг саармагжуулагч хийт төхөөрөмж,
- b. Зузаан 5 мм-ээс 15 мм,
- c. Урт 360 мм-ээс 410 мм,
- d. -40°C +50°C-ийн нөлөөллөөс хамгаалах.

7 Хамгийн бага эрсдэлээс хамгаалах бээлийд тавих шаардлага


Бээлий нь өөрийн чанарын үзүүлэлтээр хүснэгт 1-7 үзүүлсэн шаардлагад тохирохгүй бол хамгийн бага эрсдэлээс хамгаалах бээлийний төрөлд орж болно. (А хавсралт)

8 Туршилтын аргууд**8.1 Гар ба бээлийний хэмжилт**

8.1.1 Гарын бүслүүрийг металл туузан метрээр эрхий ба долоовор хурууны хоорондох салаанаас 20 мм зайд бүсэлж хэмжинэ (1-р зураг).

8.1.2 Гарын уртыг 1-р зурагт үзүүлсний дагуу миллиметрээр хэмжинэ.


8.1.3 Бээлийний уртыг дунд хурууны оройгоос бээлийний ар талын хэсгээр үзүүр хүртэл хэмжинэ (2-р зураг).



а- сарвууны урт; б- алган тал;
в- ар тал

Зураг 1

Гарын сарвууны бүслүүр ба уртын хэмжилт



а- бээлийний урт; б- бээлийний өргөн;
в- эрхий хурууны урт

Зураг 2

Бээлийний урт ба өргөний хэмжилт

8.1.4 Бээлийний уртыг хэмжихийн тулд шугамыг босоо байрлуулж, бээлийг сунгахгүйгээр үрчлээ, нугалаасыг засаж дунд хурууг чөлөөтэй байхаар тэнийлгэж тавина. Хэмжилтийн хамгийн бага уртыг миллиметрийн нарийвчлалтайгаар бичиж авна. Хэрвээ бээлий нь залгамал буюу сунадаг материалан манжеттай бол уртын хэмжээг сунгаагүй байдалд авна.

8.2 Гарын хөдөлгөөний чөлөөт байдлын түвшинг тодорхойлох арга

8.2.1 Жиших загварын тоо

Туршилтад дөрвөөс доошгүй хос бээлийг сонгоно.

8.2.2 Шаардлагатай тоног төхөөрөмж

40 см урттай 5; 6.5; 8; 9.5; 11 мм диаметртэй зэвэрдэггүй хатуу ган саваа 5 ширхэг.

8.2.3 Туршилт явуулах

Савааг хавтгай гадаргуу дээр, жишээ нь ширээн дээр, байрлуулах ба туршигч зөвхөн эрхий ба долоовор хуруугаар чимхэж авна. Туршигч саваа бүрийг дараалан гурван удаа 30 секундйн турш авч (тэмтрэхгүйгээр) тавина.

8.2.4 Үр дүн

Үр дүн нь туршилтын явцад гурван удаа 30 секундйн туршид туршигчийн өргөж чадсан савааны хамгийн бага диаметр юм.

9 Тэмдэглэгээ ба мэдээлэл

9.1 Тэмдэглэгээ

9.1.1 Бээлийнд нь хамгаалах шинж чанараар нь дүрсэн тэмдэглэгээ хийх ёстой (В хавсралт).

9.1.2 Бээлий бүр дээр дараах өгөгдлүүдийг тодорхой зааж өгсөн байна.

9.1.2.1 Нэр төрөл, худалдааны тэмдэгт буюу түүний албан ёсны төлөөлөгч;

9.1.2.2 Бүтээгдэхүүний зориулалт, худалдааны нэр төрөл буюу бүтээгдэхүүнийг нарийн тодорхойлсон хэрэглэгчид зориулсан код;

9.1.2.3 Өмсгөл хэмжээ;

9.1.2.4 Шаардлагатай тохиолдолд хэрэглэх хугацааг зааж өгсөн байх;

9.1.2.5 Хэрэв бээлий нь харгалзах стандартын шаардлагад тохирсон бол дүрсэн тэмдэглэгээг тавих.

9.1.3 Бээлийний сав боодол дээр заавал байх ёстой мэдээллүүд:

9.1.3.1 Нэр төрөл ба үйлдвэрлэгчийн буюу албан ёсны төлөөлөгчийн бүрэн хаяг;

9.1.3.2 Энэхүү стандартын 8.1.2-ын дурдсан өгөгдлүүд;

9.1.3.3 Хэрвээ бээлий нь А хавсралтад заасан эрсдэлээс хамгаалах зориулалттай бол “Зөвхөн хамгийн бага эрсдэлд” гэсэн бичиг.

9.1.3.4 Бээлийний зориулалтыг тэмдэглэсэн дүрсэн тэмдэглэгээ (Б хавсралт);

9.1.3.5 Зөвхөн сарвууны хэсгийг бээлийгээр хамгаалахад тохирох заалтууд.

10 Хадгалах нөхцөл, хугацаа,

Гар хамгаалах хэрэгслийг 60 хувиас ихгүй чийглэгтэй, +20⁰С хүртэлх дулаантай орчинд зориулалтын сав, баглаа, боодолтойгоор хадгална. Хугацаа нь эдэлгээгээр болон бүрэн бүтэн байдал алдагдах үед дуусна.

11 Анхаарах зүйл

- 11.1 Гар хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт, тухайн ажилтны хөдөлмөрийн нөхцөл тохирч байгаа эсэх.
- 11.2 Гар хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, хяналтын албаны зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл хоорондоо тохирч буй эсэх.
- 11.3 Ашиглах арга, хадгалах нөхцөл нь энэхүү стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)



**Зөвхөн хамгийн бага эрсдэлээс гар хамгаалах
хэрэгслийн тодорхойлолт**

Энэ ангилалд гарыг зөвхөн дараах үйлчлэлээс хамгаалах хэрэгсэл хамаарна. Үүнд:

- 1 Гадаргуугийн механик үйлчлэлээс (цэцэрлэгжүүлэх ажлын бээлий);
- 2 Сул үйлчлэлтэй угаалга, цэвэрлэгээний хэрэгслээс (шингэрүүлсэн угаалгын бодисоос хамгаалах бээлий);
- 3 Хүнд ноцтой түлэгдэх аюул учруулахгүй, 50°C-аас хэтрэхгүй температуртай зүйлстэй харьцах үед үүсэх эрсдэлээс;
- 4 Хүний үйл ажиллагаа, эрүүл мэндэд хор хөнөөл үзүүлэхгүй чичиргээний сул үйлчлэлээс;

В хавсралт
(мэдээллийн)

Дүрсэн тэмдэглэгээ

Дүрсэн тэмдэглэгээ	Аюулын зэрэг, зориулалт	Дүрсэн тэмдэглэгээ	Аюулын зэрэг, зориулалт
	Механик үйлчлэлээс		Цахилгаан гүйдлийн үйлчлэлээс
	Зүсэлтээс		Химийн бодисоос
	Хүйтний үйлчлэлээс		Ионы цацрагаас
	Халууны үйлчлэлээс		Угаалтаас
	Хамгаалах хэрэгслийн тайлбар (тоон үзүүлэлтээр)		

С хавсралт
(мэдээллийн)

Бээлийний эдэлгээ даах чадвар

№	Стандартад орсон химийн бодисын нэр	Нитрил	Неопрон	Натурлатекс	Винил
1	Уусмал 10% NaCe	+++	+	+++	+++
2	Сульфат зэс Cu SO4	++	++	++	+++
3	Элэгний трап	+	++	++	++
4	Магнихлорид	++	++	++	++
5	Метил этилийн кетон	++	++	++	++
6	Метиллен хлорид	++	++	+++	++
7	Сүүний хүчил	++	++	++	++
8	Натри карбонат	++	++	++	++
9	Натри гипохлоридын уусмал	++	++	++	++
10	Сульфат натри	++	++	++	++
11	Натрийн шүлт 40%	++	++	++	++
12	Натрийн шүлт 10%	++	++	+++	+++
13	Нитробензол	++	++	++	++
14	Нитро шингэлэгч	++	++	++	++
15	Тос, ургамал	++	++	++	++
16	Эрдэсийн шингэн	++	++	++	++
17	Парафины тос	++	++	++	++
18	Перехлор этилен	++	++	++	++
19	Нефтийн тос	++	++	++	++
20	Фосфорын хүчил 50%	++	+	++	++
21	Фосфорын хүчил 10%	++	+	++	++
22	Концентрацтай азотын хүчил	++	+	++	+++
23	Азотын хүчил 10%	++	+	++	+++
24	Давсны хүчил (конц)	+	+	++	+++
25	Хүхрийн хүчил (конц)	+	+	++	+++
26	Хүхрийн хүчил 50%	+	+	++	+++
27	Хүхрийн хүчил 80%	++	++	++	+++
28	Тосолгооны тос	++	++	++	++
29	Дөрвөн хлорт нүүрс төрөгч	++	++	++	++
30	Толуол	+	+	+	+
31	Трафол тос	+	++	++	++
32	Гурван хлорт этилен	+	+	+	+
33	Угаагч шүлт 10%	++	++	++	++
34	Ус	++	++	++	++
35	Перекис 30%	++	+	++	++
36	Давсны хүчил	++	++	++	++
37	Хиламен	++	++	+++	++
38	Хилал	++	++	++	++

ТАЙЛБАР 1: +++Химийн бодисоос маш сайн хамгаалах бөгөөд химийн бодист тасралтгүй байх хугацаа урт.

ТАЙЛБАР 2: ++ Химийн бодисоос сайн хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 200 цагаас бага.

ТАЙЛБАР 3: + Химийн бодисоос хамгаалах бөгөөд химийн бодист байх хугацаа 100 цагаас бага.

D хавсралт
(мэдээллийн)

Хамгаалах хэрэгслийн материалын бүтцээс хамаарч гар хамгаалах
чадварыг ангилсан ангилал

Үйлчлэлүүд	Материалын төрөл		
	Оёмол	Полимер материал	Сүлжмэл
Механик үйлчлэлүүд:			
- үрэлт	+	+	+
- хатгалт	+	+	
- зүсэлт	+	+	+
- чичиргээ	+		
Халууны үйлчлэлүүд:			
- цацрагийн дулаан	+		+
- задгай гал	+		+
- хайлмаг металлийн оч, шүрсдэс, хаг	+		+
- 40°C-аас 100°C хүртэл халсан гадаргуутай хүрэлцэх	+		+
- 100°C-аас 400°C хүртэл халсан гадаргуутай хүрэлцэх	+		+
- 4000C-аас дээш халсан гадаргуутай хүрэлцэх	+		+
Хүйтний үйлчлэл;	+		
Хоргүй тоос:			
- жижиг ширхэгтэй тоос	+		
- том ширхэгтэй тоос	+		
Рентген цацраг;		+	
Радио идэвхит бохирдол;		+	
Хүчлийн уусмал (хүхрийн уусмалаар):			
- 50%-80% концентрацитай		+	
- 20%-50% концентрацитай			
- 20% хүртэл концентрацитай			
Шүлтийн уусмал:			
- 20% хүртэл концентрацитай			
- 20% -аас дээш концентрацитай			
Ус ба хоргүй бодисын уусмал;			
Органик уусгагч түүний дотор лак ба будаг;			
Нефть, нефтийн бүтээгдэхүүн;		+	
Биологийн хортой хүчин зүйлүүд (бичил биет);		+	
Цахилгаан гүйдэл:			
- 1000В хүртэл хүчдэлтэй цахилгаан гүйдэл (хамгаалалтын үндсэн хэрэгсэл)		+	
- 1000В-оос дээш хүчдэлтэй цахилгаан гүйдэл (хамгаалалтын нэмэлт хэрэгсэл)		+	
Цахилгаан хүрээний дулааны эрсдэл;			+